

**“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 02 сарын 16 өдөр

№ 01

Дархан уул аймаг

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

“Тээвэр дархан” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурал 2024 оны 2 сарын 16-ны өдрийн 16⁰⁰ цагт гүйцэтгэх захирлын өрөөнд эхлэв.

Хуралд Компанийн ТУЗ-ийн дарга Ж.Очирсүх, ердийн гишүүн М.Оюун, М.Жавхлан, М.Цолмон, хараат бус гишүүн Д.Бумцэрэн, Д.Чулуун, Х.Жаргалсайхан нар оролцов. Мөн Гишүүн Л.Амарсанаа хэлэлцэх асуудлыг дэмжиж буйгаа утсаар илэрхийлсэн. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Жавхлантөгс хурлын ирц 77.7% хуулийн дагуу хүрч байгааг танилцуулав.

Ингээд хурлыг нээж хурал даргалагч ТУЗ-ийн дарга Ж.Очирсүх хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дэхь заалт, компанийн дүрмийн 21.1, 21.5 дахь заалтын дагуу ТУЗ ногдол ашиг олгох, эс олгох талаар шийдвэрээ гаргаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ёстой.

Хурал даргалагч ТУЗ-ийн дарга Ж.Очирсүх: Ингээд компанийн гүйцэтгэх захирал, гишүүн М.Оюун ногдол ашиг олгох, эс олгох талаар мэдээлэл өгнө.

2020-2021 онуудад цар тахлын нөхцөл байдлаас эдийн засаг, санхүүгийн байдал хүнд байсан тул ногдол ашиг олгогдоогүй юм. Санхүүгийн байдал арай дээрдэж 2022 оны ногдол ашиг олгосон. Гэхдээ урьд оныхтой харьцуулбал нэгж хувьцаанд ногдох үнийг 300 төгрөгөөр бодож олгосон. 2023 оны ногдол ашгийг олгох саналтай байна. Энэ онд мөн нэгж хувьцаанд ногдох үнийг 300 төгрөгөөр олгох саналтай байна.

Хурал даргалагч: “Тээвэр Дархан” ХК-ний ерөнхий нягтлан бодогч Д.Бямбажаргал 2023 оны үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр дүнгийн талаар тайлангаа танилцуулна.

Хурал даргалагч: Та бүхэн тайлантай танилцлаа. Хэлэлцэж буй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Санал хүсэлт байвал хэлж болно.

ТУЗ-ийн гишүүн Ж.Очирсүх: Миний хувьд дэмжиж байна.

ТУЗ-ийн гишүүн М.Цолмон: Тэгье ээ дэмжиж байна.

ТУЗ-ийн гишүүн М.Жавхлан: Зөвшөөрч байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Бумцэрэн: Дэмжье.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Чулуун: Гүйцэтгэх захирлын саналыг дэмжиж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Жаргалсайхан: Дэмжиж байна.

Хурал даргалагч: Та бүхэнд өөр санал байвал хэлж болно. Байхгүй бол хурлаас доорхи тогтоолыг гаргахаар шийдвэрлэж байна.

Та бүхэнд танилцуулья. Үүнд:

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай


Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дахь заалт, "Тээвэр дархан" ХК-ийн дүрмийн 21.1, 21.5 дахь заалт, ТУЗ-ийн 2024 оны 2 сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцогч гишүүдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 300 төгрөг олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
2. Ногдол ашгийг 2024 оны 12 сарын 31-ны дотор олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
3. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.

Хурал даргалагч: Та бүхэн хурлаас гарах тогтоолын төсөлтэй танилцлаа. ТУЗ-ийн гишүүд та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсье. Энэ удаагийн ээлжит хурал өндөрлөж байна.

Шийдвэрийг зөвшөөрсөн:

Хурлын дарга:  Ж.Очирсүх
ТУЗ-ийн гишүүн:  М.Оюун
 М.Цолмон
 М.Жавхлан

ТУЗ-ийн хараат бус
гишүүн: 

Д.Чулуун
Х.Жаргалсайхан
Бумцэрэн

ТУЗ-ийн нарийн
бичгийн дарга 

Э.Жавхлантөгс



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 16 өдөр

№ 01.

Дархан уул аймаг

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дахь заалт, “Тээвэр Дархан” ХК-ийн дүрмийн 21.1, 21.5 дахь заалт, ТУЗ-ийн 2024 оны 2 сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцогч гишүүдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 300 төгрөг олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
2. Ногдол ашгийг 2024 оны 12 сарын 31-ны дотор олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
3. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.



Хурлын дарга

Ж.Очирсүх